



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (975-51) 26 08 17, Факс: (975-51) 26 24 08,
Цахим ирүүдэг: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2013. 10. 03 № 35-1/130
танай _____-ны № _____-т

Асуудал зөвшилцөх тухай

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



ЛОЮУН-ЭРДЭНЭ

000234003663

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд:

"III.ХЭЛЭЛЦСЭН нь: Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл
Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам
нээн ажиллуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.5.8.-т "Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.5.8.1.-т "ДТГ-уудын байршил, бүтэц, орон тооны асуудлыг ач холбогдлыг нь харгалзан тухай бүр шийдвэрлэнэ." гэж тус тус заасны дагуу Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах саналыг боловсруулав.

Бүгд Найрамдах Узбекистан Улс нь тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүний Бүгд Найрамдах Улсуудтай шууд хамтын ажиллагаа өргөжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн шийдвэрийн дагуу 1977 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо манай Ерөнхий консулын газар нээгдэн 1994 он хүртэл ажиллаж байсан байна. Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа буюу 1992 онд хоёр талын уламжлалт найрсаг харилцаа, тус улсын Төв Азийн бүс нутагт дахь нөлөөг харгалзан Монгол Улс Бүгд Найрамдах Узбекистан Улстай дипломат харилцаа тогтоосон.

Узбекистан нь хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан Казахстан, Киргиз болон Тажикистан зэрэг Төв Азийн орнуудтай харьцуулахад манай хоёр хөрштэй хил залгадаггүй, бүс нутгийн дийлэнх улсуудын адил Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, Евроазийн эдийн засгийн холбоо зэрэг байгууллагын гишүүн биш, бие даасан гадаад бодлого явуулахыг эрхэмлэдэг, тухайн бүс нутагтаа улс төрийн нэр хүнд бүхий улс юм. Өнөөдрийн байдлаар тус улсад гадаадын 44 улсын Элчин сайдын яам, 2 Ерөнхий консулын газар, 18 Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллаж байна. Тус улс нь сүүлийн жилүүдэд бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй шинэчлэлийг өрнүүлж, улс төрийн тогтолцоо, нийгэм, эдийн засгийн олон өөрчлөлт, шинэчлэл хийж эхлээд байгаа бөгөөд энэ нь мөн гадаад бодлогод хамааралтай байна. Тухайлбал, Узбекистан нь 2020 онд Евразийн эдийн засгийн холбоонд ажиглагч статустай болсон, саяхан Дэлхийн худалдааны байгууллагад элсэх хүсэлтээ илэрхийлээд байгаа юм.

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн 2023 оны 3 дугаар сард Бүгд Найрамдах Узбекистан Улсад хийсэн албан ёсны айлчлал нь хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш хэрэгжсэн анхны өндөр түвшний айлчлал болсон бөгөөд энэ үеэр талууд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн газрын хооронд хоёр талт хамтын ажиллагааны хамтарсан комисс байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан. Түүнчлэн Монгол Улсаас Төв Азид чиглэсэн гадаад бодлогыг идэвхжүүлэх зорилтын

хүрээнд Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Элчин сайдын яамыг Ташкент хотноо нээх тодорхой нөхцөлийн талаар Гадаад харилцааны сайд нарын түвшинд дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцсон болно.

Узбекистан нь 35 сая гаруй хүн амтай, бүс нутгийн хэмжээнд томоохонд тооцогдох зах зээлээс гадна хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хувьд тухайн бүс нутагтаа тэргүүлдэг бөгөөд Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн эрүүл хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр хамтран ажиллах өргөн боломж бүхий улс юм. Мөн Төв Азид манай үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилгоор үзэсгэлэн, яармаг худалдааг зохион байгуулах, худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, мах болон махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломж байна.

Хоёр талын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд аажмаар өсөн 2022 онд 10,4 сая ам.долларт хүрсэн бөгөөд хоёр улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд 2022 онд Ташкент хотод Монгол, Узбекистаны бизнес уулзалтыг хамтран зохион байгуулсан.

Монгол, Узбекистаны худалдааны статистик мэдээлэл								
Нэр	2019 он		2020 он		2021		2022 он	
	Экспорт мян.\$	Импорт мян.\$	Экспорт мян.\$	Импорт мян.\$	Экспорт мян.\$	Импорт мян.\$	Экспорт мян.\$	Импорт мян.\$
Үнэ	58.6	2 025.3	98.4	2 506.7	376.5	3 453.0	4 193.8	6 225.7
Нийт	2,0 сая ам.доллар		2,6 сая ам.доллар		3,8 сая ам.доллар		10,4 сая ам.доллар	

Монгол Улс Узбекистан болон тус бүс нутгийн бусад улсаас хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Цаашид ч Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд нийлүүлэгч улсын тоог нэмэгдүүлэх зорилгоор улс төрийн хувьд төвийг сахисан, бүс нутагтаа нөлөө бүхий улстай илүү ойр ажиллах нь зүйтэй хэмээн үзэж, хоёр талын харилцааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохоод чиглэсэн Засгийн газар хоорондын хэлэлцээр, санамж бичгүүдийг байгуулахаар ажиллаж байгаа болно.

Иймд бүс нутагтаа улс төр болон эдийн засгийн хувьд ач холбогдол бүхий Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яамыг нээн ажиллуулах бодитой хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан энэ асуудлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөх саналтай байгаа болно.

Элчин сайдын яамыг 3 орон тоотой ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох зардлыг 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТАШКЕНТ ХОТОД НЭЭГДЭХ ДТГ-ЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

№	Зардлын зүйл	Төсөв /ам.доллороор/ 3 орон тоо	Төсөв /мян.төгрөгөөр/ ханш 3900₮
1	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	355,809.60	1,387,657.44
	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	355,809.60	1,387,657.44
2	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,809.60	1,387,657.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	138,309.60	539,407.44
210101	Үндсэн цалин	138,309.60	539,407.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,100.0	417,690.0
210301	Гэрэл цахилгаан	3,000.00	11,700.00
210302	Түлш халаалт	4,000.00	15,600.00
210303	Цэвэр бохир ус	1,000.00	3,900.00
210304	Байрны түрээс	99,100.00	386,490.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,500.0	21,450.0
210401	Бичиг хэрэг	1,000.00	3,900.00
210402	Тээвэр шатахуун	2,000.00	7,800.00
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	2,000.00	7,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс аж ахуйн материал	500.00	1,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000.0	58,500.0
210601	Багаж техник хэрэгсэл	15,000.00	58,500.00
210604	Урсгал засвар		-
2107	Томилолт, зочны зардал	25,000.0	97,500.0
210701	Гадаад албан томилолт	20,000.00	78,000.00
210702	Дотоод албан томилолт		-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000.00	19,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж	47,100.0	183,690.0
210803	Даатгалын үйлчилгээ	46,100.00	179,790.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.00	3,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,800.0	69,420.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,800.00	69,420.00
213	Татаас ба урсгал шилжүүлэг		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	355,809.60	1,387,657.44
	Төсвөөс санхүүжих	355,809.60	1,387,657.44

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Бүгд Найрамдах Узбекистан Улсад
Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай

Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар тогтоосугай.

ГАРЫН ҮСЭГ

**Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ташкент хотод
Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай
асуудлаарх ажлын хэсэг**

1. Б.Батцэцэг -Гадаад харилцааны сайд
2. Н.Анхбаяр -Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга
3. Г.Хулан -Гадаад харилцааны яамны Ази, Номхон далайн орнуудын газрын захирал
4. Б.Болд -Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал
5. Д.Амарсайхан -Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал
6. Ч.Ганбат -Гадаад харилцааны яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

---oOo---